

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-22

- 1. “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/** 3-22

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Х.Тэмүүжин, Ө.Шижир, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Л.Энхнасан, Р.Эрдэнэбүрэн.

Нэг. “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Энхтүвшин, Г.Тэмүүлэн, Н.Номтойбаяр, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, С.Ганбаатар, Д.Цогтбаатар, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 08 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 16 цаг 19 минут*

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Хажикберын Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал байгаа.

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай. Засгийн газар 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр буюу өнөөдөр нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр оруулж ирсэн асуудал байна. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаас нэн яаралтай горимоор хэлэлцэх асуудлыг олонхоороо дэмжээд ингээд орж ирж байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу. Алга байна. Асуудлаа хэлэлцье.

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанийн гүйцэтгэх захирал Алтанцэцэг, тус компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга Чинзориг гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна.

Ингээд 2 улсын хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банктэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл нь хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслөөс хамгийн түрүүнд үйл ажиллагаа нь хэрэгжиж, үр өгөөжөө өгч эхлэх, эдийн засаг, стратегийн өндөр ач холбогдолтой төсөл юм.

Улсын Их Хурлын зүгээс төслийн санхүүжилтэд шаардлагатай нийт 1 тэрбум 236 сая ам.долларын зээлийн хэлэлцээрүүдийг 2017, 2019 онуудад тус тус соёрхон баталсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар төслийн хүрээнд 268 сая ам.долларын эх үүсвэрийг ашиглаж, төслийн нийт ажлын гүйцэтгэл 23,5 хувьтай байна.

Ковидын дараах тээвэр логистик, бараа материалын үнийн өсөлт, түгээлт, тээвэрлэлтийн дэд бүтцийг манай орны цаг уурын нөхцөлд тохируулах зэрэгтэй холбоотойгоор техникийн зарим нэмэлт, өөрчлөлт оруулах болсон нь төслийн хэрэгжилтийн явцад төслийн зардлыг өсөхөд гол нөлөөлсөн байна.

Мөн нарийвчилсан ТЭЗҮ-ийн тодотголыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны харьяа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2023 оны 9 дүгээр сард хэлэлцэн төслийн нийт өртгийг 1 тэрбум 698 сая ам.доллар болгож баталгаажуулсан байна. Үүний дагуу Засгийн газрын зүгээс газрын тос боловсруулах, барих төсөлд шаардлагатай нэмэлт санхүүжилтийн хүсэлтийг 2023 оны 10 дугаар сард Энэтхэгийн талд хүргүүлэн, зээлийн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр ажилласны үр дүнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зүгээс зээлийн хүсэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр албан ёсоор шийдвэрлэсэн.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээр”-ийн төслийг 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн бөгөөд улмаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлэн зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосон.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд газрын тос боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийн зээлийн хэлэлцээрт 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр гарын үсэг зураад байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээр нь өмнөх 236 сая ам.долларын зээлийн дүнг нэгтгэснээр 700 сая ам.доллар, зээлийн нөхцөл нь өмнөх зээлийн адил нөхцөл нь үргэлжилж байгаа буюу жилийн 1,75 хувийн хүүтэй, үйлчилгээний шимтгэл болон хөрөнгө нөөшилөн баталгаажуулсны шимтгэл тус бүр 0,5 хувь, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, нийт 20 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй болно.

Тус зээлийн хэлэлцээр байгуулагдсанаар газрын тос боловсруулах, барих төслийг бүрэн хэрэгжүүлж, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулан жилд 1,5 сая тонн түүхий тос боловсруулж, шинээр 700 гаруй ажлын байр бий болгох, дотоодын шатахууны хэрэгцээний 55-аас доошгүй хувийг хангаж, жил бүр 1 тэрбум гаруй ам.долларын гадагшлах урсгалыг зогсоон төлбөрийн тэнцлийг сайжруулах

замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой стратегийн төсөл юм.

Байнгын хорооны дарга, дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон дагалдан боловсруулсан хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад хууль санаачлагчаас асуулт асууж үг хэлэх гишүүд байна уу. Гишүүдийн нэрсийг авъя. Жаргалан гишүүнээр тасалъя. Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Ганбаатар: Энэ төсөл бол чухал төсөл. Монгол оронд хамгийн чухал төсөл. Тэгэхдээ бид гоомой юм хийж, сүүлд нь алдаанд орж болохгүй. Анхнаас нь Монголчууд бүгдээрээ энэ төслийг дэмжиж байсан. Гэхдээ ямар ч ТЭЗҮ, тооцоо судалгааг нь харахгүйгээр энэ олон 100 сая долларыг зүгээр батлаад байна гэвэл дараа нь бид хэрэгт орно шүү. Дараа нь бид хариуцлага үүрнэ шүү. Та нар мэдэхгүйгээр шийдвэр гаргавал хамаа алга. Одоо мэддэг боллоо. Би энд мэдээлэл өгье.

1 дүгээрт миний асуух асуулт. Төслийн ТЭЗҮ-ийн ажлыг 2017 онд боловсруулж эхлээд, 2018 оны 10 дугаар сард тайлан, илтгэлийг нь Эрдэс баялгийн зөвлөлөөр баталсан гэж ярьдаг. Энэ ТЭЗҮ-г ер нь энэ 2018 оноос хойш энэ 5 жилд харсан хүн байна уу. Би энэ ТЭЗҮ-г харж байж дүн шинжилгээ хийсэн дүгнэлтийг нь харж байж шийдвэр гаргая гэж хэлсэн. Энийг яг хариуцаж байгаа албан тушаалтнууд нь, энэ улс төрчид маань, гишүүд маань харсан уу. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Түүхий тосны хангамж, үгүй ээ энэ чинь түүхий тосны хангамж ямар ч байхгүй байхад бид энэ дээр шийдвэр гарч болж байгаа юм уу. Энэ олон тэрбум долларыг тэгээд тэр чигт нь тавих уу. Энэ чинь олон 100 сая сургууль, цэцэрлэг, эмнэлгийн мөнгө шүү дээ. Модь анх өгөхдөө бол нийгмийн гэж ярьсан шүү. Тэгэхдээ газрын тосон дээр дуртай. Бүгдээрээ. Энэ бол бидний тусгаар тогтнол. Тэгэхдээ хэдэн жилийн дараа тэгээд бүгдээрээ үр дүнгүй болчихсон байвал бид өнөөдөр хэнийгээ гэх вэ дээ, гайны бага дээр, газрын ойр дээр энийгээ нягталъя гэж байгаа юм.

Тэгээд миний асуух зүйл гэвэл түүхий тосны хангамж зарчмын хувьд ТЭЗҮ-д бүрэн баталгаажсан байх ёстой. Тэрийг хармаар байна. Үзмээр байна. Энэ алга. Үйлдвэрт зөвхөн Хятадын Петро чайна Дачин Тамсгийн компанийн олборлосон түүхий тосыг ашиглах тийм асуудлууд байгаа юу. Тэд нартай гэрээнүүдээ байгуулсан уу. Бүр 100 хувь авна гэж. Түүхий тосны олборлолт 2012 оноос хойш шаардлагатай 1,5 сая тоннд огт хүрээгүй байгаа. Энэ жил гэхэд л миний авсан мэдээллээр бол 500 мянган тонн байгаа. Яаж үйлдвэрлэлийн хүчин чадалдаа хүргэх вэ. Өөр эх үүсвэр байгаа юм уу. Энэ дээр ТЭЗҮ талаас тооцоо, судалгаа хийсэн юм бий юу.

3 дугаар асуудал. Усны усны хангамж хангалттай юу. Энэ дээр түүхий тосны үйлдвэр бол өөрөө их ус ашигладаг. Олон 10 жилийн хугацаанд хийгдсэн олон улсын болон Монголын мэргэжлийн байгууллагуудын гидрогеологийн хайгуул судалгаагаар Алтан ширээ орших говь бүсэд цэвэр усны нөөц байхгүй гээд гарчихсан байна. Тэгээд ийм усны нөөц байхгүй байхад энэ үйлдвэр цаашаа явах уу. Тэгээд энэ мөнгийг батлах эр зоригтой хүн байгаа юм уу. Ийм юм хийе, бүтээе гэж байгаа хүмүүсийг би дэмжинэ. Ганцхан ТЭЗҮ, тооцоо байхгүй бол энэ чинь зүгээр мөрөөдлөөс болоод Монголын ард түмний энэ олон 100 сая долларыг бид ингээд салхинд хийсгэж болохгүй. Энэ чинь өөрөө ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Алтанцэцэг захирал уу. 5 номер.

Д.Алтанцэцэг: “Монгол Газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал Алтанцэцэг байна. Би Ганбаатар гишүүний асуултын ТЭЗҮ, устай холбоотой 2 асуултад хариулъя. Түүхий тостой холбогдсон асуудлыг манай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Хишигдалай хариулна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ бол хийгдсэн. 2017 онд тухайн үеийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас зарласан тендерт Энэтхэгийн “Инженерс Индиа” компани шалгарч, энэ ажлыг бол 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. ТЭЗҮ-ээр бол энэ үйлдвэрийг барих боломж байгаа. Барьж байгуулаад дараа нь Монгол Улсад нийгэм, эдийн засгийн үр ашигтай гэсэн ийм шийдвэр гарсны дагуу Монгол Улсын Засгийн газар 2017 онд энэ үйлдвэрийг барихаар шийдвэрлэсэн. ТЭЗҮ-ийг “Инженерс Индиа” компани боловсруулж Итали Улсын “Кинетикс технологи” хөндлөнгийн хяналтыг тавьж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж, хүлээж авсан.

Ганбаатар гишүүн бол манай компани дээр ирж ТЭЗҮ-тэй бас нэлээн нарийн танилцаж байсан анхны хүмүүсийн 1. 2021 онд та манай компани дээр ирж байсан. Мөн Аж үйлдвэржилтийн байнгын хорооныхон бид бол бүх зүйлээ бас нэлээн нарийн тайлбарлаж өгч байсан.

Усны талаар ярих юм бол ер нь үйлдвэрийн байршлыг сонгосон бас нэг шалтгаан нь усны эх үүсвэр байсан. 2012 онд хийсэн Сайншандын аж үйлдвэрийн парк цогцолборын хүрээнд хийсэн энэ судалгаануудаар Бор хөөврийн говийг аж үйлдвэрийн паркийн байгууламжууд, үйлдвэрүүдийг усан хангамжаар ашиглах хамгийн тохиромжтой хувилбар гэсэн ийм шийдвэр байдаг юм байна лээ. Ингээд тухайн үеийн Байгаль орчны яамны Усны нөөцийн газрын 2014 оны тогтоолоор Бор хөөврийн говийн гүний уснаас Сайншандын аж үйлдвэрийн паркт баригдах тодорхой нэлээн олон үйлдвэр байгаа юм. Тэр дотор бас газрын тос боловсруулах үйлдвэрийг усаар хангана гэсэн ийм шийдвэрийн дагуу үйлдвэрийн усан хангамжийг Бор хөвүүрийн говиос бол хангахаар шийдвэрлэсэн.

Г.Тэмүүлэн: Асуултуудад хариулъя. 4 Номер Хишигдалай. Аж үйлдвэр, уул уурхай яам.

Ч.Хишигдалай: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Хишигдалай. Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс газрын тосны геологийн нөөцөөрөө бол 340 сая тонн орчим тонн геологийн баталгаат нөөцтэй. Үүнээс ашиглалтын баталгаат нөөц бол 41,5 сая тонн. Үүнээс бид нар 10 орчим сая тонныг олборлоод экспортолчихсон байна. Гол олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Петро Чайна ДаӨчин Тамсаг компанийн Тосол уул 19, Тамсаг 21 талбай дээр бол олборлолтын төлөвлөгөө ёсоор 1,5 сая тонн газрын тосыг 10 орчим жил олборлохоор орд ашиглалтын төлөвлөгөөг батлуулж байсан.

2014, 2015, 2016, 2017 онуудад бол 1 сая орчим тонн газрын тосыг олборлоод, экспортлоод явж байсан боловч 2018 оноос олборлолтын хэмжээ буурсан. Энэ нь юутай холбоотой вэ гэвэл зах зээл дээрх газрын тосны үнэ буурсан гэж байгаа юм. Байгалийн горимоор олборлох боломж бас .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Хишигдалайд нэмж минут өгье. 4 номер.

Ч.Хишигдалай: Хамгийн гол энэ асуудал дээр Хятадуудын хөрөнгө оруулалт хийхээс татгалзаж байгаа зүйл бол Монгол Улсын татвар, Нийгмийн даатгалын багц хуулиуд өөрчлөгдсөн. Үүнтэй холбоотой Петро Чайна Дачин Тамсаг компани дээр маш олон төрлийн татварын акт торгуулиуд тавигдсан. Хятадууд маань юу ярьж байна вэ гэвэл та нар хөрөнгө оруулаач ийм эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчин байна гэж оруулж ирээд бид нарын 4 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтыг хийлгэчихээд, үйл ажиллагаа жигдрээд ашиг орлогоо олох гээд эхэлж байтал та бүхэн манай хууль тогтоомж өөрчлөгдлөө, үүнтэй холбоотой ийм ийм татвар төл, ингэ, тэг гэж байна. Ийм учраас энэ хөрөнгө оруулалтын таатай орчинд бид нар хөрөнгө оруулах боломжгүй байна гэдэг асуудлыг ярьдаг.

Газрын тосны салбарын онцлог нь юу вэ гэвэл тухайн ашиглалтын талбай дээр тогтмол хөрөнгө оруулалтыг шаардаж байдаг. Тогтмол технологийн ажлууд хийгдэхийг шаардаж байдаг. Тэгэхээр бол энэ олборлолтын хэмжээ буурсан нь үүнтэй бол шууд холбоотой байгаа юм. Тэгэхээр бид энэ бүтээгдэхүүн хуваах гэрээ, түүнтэй холбоотой асуудлуудыг нэн даруй .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сангийн яамнаас нэмж хариулъя. 5 номер. Хэн хариулах вэ. Уул уурхайн яамнаас 4 номер.

Ч.Хишигдалай: Тэгэхээр энэ бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой маргаантай асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байгаа. Хэрвээ энэ асуудлыг шийдвэрлэвэл бид тухайн талбайнууд дээр хөрөнгөө оруулна. Нэмж хайгуулын талбай дээр хөрөнгө оруулж, үйлдвэрийг тосоор хангах бүрэн боломжтой гэдгээ бол Хятадын тал илэрхийлчихсэн байгаа.1 дүгээрт.

2 дугаарт олборлож байгаа тосыг газрын тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх үү гэдэг асуулт сая тавилаа. 2011 оны 6 дугаар сарын 24-нд Газрын тосны газар Петро Чайна Дачин Тамсаг газар 2-ын хооронд байгуулсан протокол байдаг. Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулагдсан тохиолдолд Петро Чайна Дачин Тамсаг компани бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу өөрт ноогдох түүхий тосыг тэргүүн ээлжид Монгол Улсад нийлүүлнэ гэдгийг уг протоколоор протоколдоод энэхүү протокол нь бүтээгдэхүүн хуваах гэрээний салшгүй нэг хэсэг болно гэдгийг баталгаажуулаад 2 талаас гарын үсэг зураад баталгаажуулчихсан байгаа.

Сая 2024 оны 9 сард Монгол Улсын Ерөнхий сайд БНХАУ-д айлчилж, уг компанийн ТУЗ-ийн даргатай уулзсан байгаа. Тухайн үеээр энэ протоколын асуудал болон бусад асуудлууд мөн яригдсан байгаа.

Г.Тэмүүлэн: 4 номер.

Ч.Хишигдалай: 2024 онд нийтдээ 568 мянган тонн газрын тос олборлож, 552 мянган тонн газрын тос экспортолсон. Энэ жил 2025 онд 750 мянган тонныг олборлоно гээд олборлолтын төлөвлөгөө боловсруулаад явж байна. Энэ хөрөнгө оруулалтын таатай орчныг хэвээр үлдээх бүтээгдэхүүн хуваах гэрээг хэвээр үргэлжлүүлсэн тохиолдолд бид нар танай үйлдвэрийг 100 хувь тосоор хангах боломжтой гэдгээ бол Хятадын тал илэрхийлээд хэлээд байгаа.

Г.Тэмүүлэн: Хишигдалай. 4 номер.

Ч.Хишигдалай: Түрүүн би дурдсан ашиглалтын баталгаат нөөц 41,5 сая тонн батлагдсан. Үүнээс бид нар 10 саяыг нь олборлоод, экспортолчихсон байна. Одоо цаана нь 31 сая тонн газрын тос байна. Үүнийг олборлоод үйлдвэртээ нийлүүлээд бид нар 20 жил үйлдвэрийг хангах тооцоотой. Ер нь улс орнуудын жишгээр геологийн баталгаат нөөцөөс ашиглалтын баталгаат нөөцийн олборлох хувь 10-25 хувь байдаг. Зарим газар бүүр Петро Чайна Дачин ойлд бүр 40 хувьд хүрчихсэн байгаа. Манайх бол зөвхөн 10 хувиар энийг олборлоно гэсэн тооцоо дээр явж байгаа гэдгийг энд дурдах нь зүйтэй байх.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Үгүй ээ, ингээд л амаар л яриад байх юм. Алтанцэцэг дарга дээр бол би 2 ч удаа тэр хамт олон дээр очиж байсан. Презентац тавьсан. Тэгэхдээ би ТЭЗҮ үзээгүй. Гайхалтай гоё хамт олон. Тэгээд бид нар бүгдээрээ дэмжиж байгаа гэдгээ илэрхийлсэн. Тэгэхдээ ТЭЗҮ байхгүй бол наадах чинь үлгэр болчихоод байна шүү дээ. Худлаа яриад байна шүү дээ та нар. Та нар хүмүүс хуурч байна шүү дээ. Та нар ТЭЗҮ гээд о саяын ярьсан юмыг аль сайдад өгсөн юм. Аль гишүүд үзэж байгаа юм. Та нар зүгээр амаараа ярьж болно. Хариуцлагыг нь та нар яг хар толгойгоороо үүрэх юм уу. Өнөөдөр усны тэр байгаль орчны нарийвчилсан нөлөөллийн үнэлгээ гарсан юм уу. Яг усан дээр баталгаатай гэдэг нь хэдэн эрдэмтэн гаргасан юм. Тэр үнэлгээг үзэж болох уу. Бид Улсын Их Хурлын гишүүд шүү дээ. ТЭЗҮ үзэж болох уу. Эксим банктай яг тэр баталгаажсан цаасыг нь үзэж болох уу. И Пи Си гэж байгаа шүү. Тэр ерөнхий гэрээлэгчийн тэр бүх цаас бичгийг нь үзэж болох уу. Энэ цааснуудыг үзэж байж бид шийдвэр гаргаж болох уу. Би ерөөсөө эсэргүүцээгүй шүү дээ.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 5 номер. Монгол газрын тос Алтанцэцэг захирал.

Д.Алтанцэцэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Амаар ТЭЗҮ хийнэ гэж байхгүй. Та ТЭЗҮ-тэй бүх албан бичгүүдтэй, харилцсан харилцаа, инженерчлэлийн зураг төсөл, суурь инженерчлэл, дител инженеринг, 2, 3 хэмжээст модель бүх загвартай та танилцаж болно.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

С.Ганбаатар: Уг нь би хүнийг хүндлэх их дуртай юм сан. Их том байна. Танилцаж болно гишүүд ээ, та нарт бол үзүүлж болно шүү дээ. Тэгээд одоо би үгүй мөн их тэвчээртэй, хүндлэх гэж л оролдож байгаа хүн дээ. Энэ болно оо биш ээ. Улсын Их Хурлын гишүүд Монголын ард түмний өмнөөс дараа нь Монголын ард түмэнд төлөх энэ 400 сая доллар байна уу, 2,2 тэрбум долларын талаар шийдвэр гаргахдаа энэ ТЭЗҮ болон ТЭЗҮ, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтүүдийг харж байж шийдвэр гаргах ёстой. Тэгэхгүйгээр зүгээр та нар харанхуй, ухаантай царайтай, гоё ярьсан юмны талаар итгээд шийдвэр гаргаж байгаа бол та нар хууль зөрчиж байгаа явдал шүү. Ийм тэнэг арчаагүй байдлыг зогсоох гэж, Улсын Их Хурлын гишүүд бид өнөөдөр сонгогчдынхоо өмнө хариуцлага үүрч байгаа шүү. Надад 27 асуулт байгаа. Би дөнгөж гуравхныг нь асуусан. Би 27 асуултдаа бүгдийг нь тэр шинжээчдийн дүгнэлтийг үзэж байж би шийдвэр гаргах ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: 1 асуулт байна. Сая Жавхлан сайдын танилцуулга дотор Энэтхэгийн Засгийн газраас нэмэлт санхүүжилтийн зөвшөөрөл 11 сарын 26-нд өгсөн гэдэг танилцуулга хийгдэж байна. Тэгээд төсөв маань 12 сарын 4-нд орж ирсэн. Тэгэхээр яах вэ, энэ асуудлыг тэр төсөв хэлэлцэх үед оруулж ирж бас ярих боломжгүй байсан уу. Тэр үеэс бас бид энэ газрын тостой холбоотой санхүүжилтийг нь бас шийдчихье. Энийг нь хаанаас нь мөнгө гаргаад зардлуудаа багасгаад ч юм уу оруулъя гэж тиймэрхүү яриа болж байсан. Тэгээд тэр үед болохоор ерөөсөө орж ирэхгүй, мэдээлэлгүй байсан. Тэгээд энэ дээр ямар шалтгаан байсан юм бэ гэж тодруулга авъя.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд асуултад хариулъя.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Одоо эргээд харахаар яах вэ, цаг хугацааны хувьд тэгж харагдаж байгаа байх. Энэ 11 сарын 26-нд манайх ингээд Эксим банк зээл өгөхөөр шийдлээ гэж л хариугаа ирж байгаа юм. Тэрнээс хойш чинь ингээд бид нар бараг сар гаруй хугацаанд хэлэлцээр хийж байгаа байхгүй юу. Хэлэлцээр хийгээд, тэгээд энэ чинь ерөөсөө сая 1 дэх, 2 дахь өдөр Байнгын хороогоор ороод, зөвшилцөх эсэх зөвшөөрлөө аваад, тэгээд би гарын үсэг зураад, эндхийн тал руугаа яваад урьд шөнө хамгийн эцсийн байдлаар ирж байгаа юм. Одоо ингээд соёрхон батлаад, тэгээд гэрээнд гарын үсэг зурмагц энэ зээлийн харилцаа нь үүсээд зээл авах боломж нээгдэнэ гэсэн үг.

Тэгээд яах вэ, хэдүүлээ энэ жил 350 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтаа ямар ч байсан суулгачихсан байгаа. Хоосон ч арай биш. Харин ингээд зээлийн харилцаа эхэлмэгц бид нар энэ жилдээ дор хаяж 1,7 их наяд төгрөгийн зээлийн ашиглалт гаргах хэрэгтэй байгаа. Тэгж байж энэ гэрээ зурагдсанаас хойш 38 сарын дараа бүрэн ашиглалтад орох ийм гэрээ эхлэх юм байгаа юм. Тэгэхээр жил бүр 1,7 их наяд, 1,6 орчим их наядыг явуулж байж бид нар 1,7 тэрбум доллар гэдэг маань өөрөө энэ чинь нөгөө 4,2 их наяд учраас ингэж дуусгах хэрэгтэй болж байгаа. Тэгээд энэ дээр бид Засгийн газрын гишүүддээ Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдэд энэ завсарлагаагаар бас танилцуулга хийж, хэдүүлээ хамтарч шийдэх л нэг ийм асуудал байгаа. Одоо дараагийн яг сорилт тэр л болж таарах нь. Нөгөө Үндсэн дүрмээ зөрччихгүй. Манай дүрэм бол буруу байхгүй. Төсвийн дүрэм бол чанга, зөв. Харин яг ийм стратегийн төслүүд дээрээ энэ зээл маань өөрөө бусад эрүүл мэндийн ч гэдэг юм уу боловсролын салбарын нөгөө урсгал зардлаас өөр нь эх

үүсвэртэй зардал байхгүй юу. Долларын эх үүсвэртэй. Нөгөөдүүл нь маань бол эх үүсвэргүй урсгал зардал. Тэгэхээр энэ эх үүсвэртэй учраас энэ дээр нэг удаа энийгээ ашиглалтад оруулахын тулд үр өгөөжийг нь авахын тулд нэг тийм өөрчлөлт хийхээс аргагүй л болох нь дээ. Тийм санал оруулж ирнэ л гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Нэмэлт санхүүжилттэй холбоотойгоор одоо үндсэн зээлийн төлбөр эхэлчихсэн байгаа. Тэгэхээр энэ онд болоод, ирэх онд үндсэн зээлийн төлбөрүүд ямаршуу дүн байгаа юм. Хэлэлцээр хийж байгаад тодорхой дүн багасгачихсан гэж байсан. Тэр талаар мэдээлэл өгөөч.

2 дугаарт яг үүнтэй адилхан бас яг зээлийн нөгөө хязгаарт оруулахгүй байхаар өөр ийм том төсөл бас байгаа юу гэдэг талаар мэдээлэл өгөөч.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүний асуултад нэмж хариулъя. Одоо жишээ нь 2019 онд зээл маань эхлээд 5 жилийн дараа 2019, 2020, 2021, 2022, 2023 гээд 2023 онд эхний үндсэн төлбөр эхлэх ийм хуваарьтай байж байсан. Гэтэл юун эхний төлбөр манатай энэ чинь 268 сая доллар ашиглачихсан. Тэгснээ бүр 64 сая доллар төлөх ийм хугацаа болчихсон байсан юм. Тэгээд бид нар хэлэлцээр хийгээд хагас жил хийсэн. Ингээд 7 жил хойшлуулчихсан юм. Тэгэхээр одоо эхний үндсэн төлбөр 2029 онд эхэлнэ. Ирэх жилүүдэд бол байхгүй.

Өөр төслүүд гэх юм бол үүний дараа бид нар цэвэрлэх байгууламж байна. Мянганы сорилтын сангийн төсөл байна. Тэгээд хэдэн дулааны төслүүд байна. Дулааны станцын төслүүд байгаа. Ер нь яг эрэмбэлэх юм бол нэг эхний 10-ын дандаа дэд бүтцийн төслүүд бол бүгд л чухал. Тэгэхдээ энэ бол харьцангуй хамаагүй том байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Саяын Энхтүвшин гишүүний асуусан асуулт дээр би зүгээр дахиад тодруулга аваадахъя. Энэ бас сая яг асуулт гарч ирэнгүүт нэг ойлгомжгүй зүйл гарч ирээд байх юм. Ерөнхийлөгчийн хориг тавигдаад, төсөв дахин өргөн баригдсан. 12 сарын 4-нд өргөн барьсан байна. 12 сарын 4-нд баригдсан төсвөөс өмнө 11 сарын 26-нд та сая Энэтхэгийн Засгийн газраас албан ёсны хариугаа бол ирүүлж, энэ зээлийн хэлэлцээрийг шийдвэрлүүлэхээр шийдвэрлэсэн гээд албан ёсоор бол хариугаа өгсөн байна гээд тэгж байгаа юм. Тэгээд яагаад 11 сарын 26-нд Энэтхэгийн Засгийн газар шийдчихсэн байхад энэ асуудлыг төсөв дээрээ та суулгаагүй орж ирсэн юм бэ. Бид нар бол тухайн үед бас төсвийн ажлын хэсэг гараад ажилласан. 5 хоног ажилласан. Бид нар тэгээд 12 сарын 12-нд баталсан. Тэр үед бас Төсвийн байнгын хороо дээр ч, ажлын хэсэг дээр ч бас асууж байсан зүйл нь Энэтхэгийн зээлийн хэлэлцээрийн асуудал бол үндсэндээ Монгол Улсын байгуулсан зээлийн хэлэлцээр дотроосоо номер 1 асуудал. Бид бүхний эрх ашгийн эрэмбийн хүрээнд бол байгуулах, бүтээн байгуулах номер 1 асуудал гээд. Тэгээд энэ дээр зээлийнх нь дүнг нь багасгасан асуудал гээд 300 хэдээр орж ирж байсан асуудал дээр бол та төсөв дотроо 1,5 тэрбум долларын зээл байгаа. Анх өргөн барихдаа бол 2 байсан. Шинээр өргөн барьсан төсөв дээр 1,5 болгож бууруулж ирж байсан. Тэгээд энэ дээр бол би төсвийнхөө гүйцэтгэлээс хамаараад бол зохицуулалтуудаа хийнэ. Боломж бол байгаад байгаа гэдэг асуудлыг бол ярьж байсан юм. Гэтэл өнгөрсөн сая 3, 4 хоногийн өмнө яг энэ зээлийн хэлэлцээрийг зөвшилцөх эсэх асуудлыг орж ирэхэд одоо энэ Энэтхэгийн зээлийн албан ёсны

хариу ирсэнтэй холбогдуулаад бид нар дахиад төсвөө өргөн барихаас арга байхгүй болсон. Төсөв дээрээ тодотгол хийнэ гэдэг бас нэг талдаа ийм хариуцлагагүй мэдэгдэл хийгээд байгаа юм. Тэгээд дөнгөж төсөв хэрэгжиж эхлээд 15 хоногийн дараа ингэж ярьж болдог юм уу.

Дээрээс нь энэ зээлийн хэлэлцээр чинь Энэтхэгийн Засгийн газраасаа бол төсөв өргөн баригдахаас өмнө албан ёсных нь хариу нь бол шийдчихсэн байсан асуудлыг яагаад ингээд төсөв дээрээ та суулгаагүй орж ирээд, тэгээд 11 сарын 26-нд орчихсон байсан асуудлыг Засгийн газрынхаа хуралдаанаар 1 сарын 8-нд оруулж ирээд, шийдүүлж байгаа юм бэ. Оны өмнө Засгийн газар нь хуралдаж шийдвэрлээд Улсын Их Хурлаар оруулж ирж болоогүй юм уу. Ингээд хугацаа тулгаад чуулган завсарлах хамгийн сүүлийн хоног дээр ингэж орж ирж байгаа чинь зарчмын хувьд зөв юм уу. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэмүүлэн даргын асуултад хариулъя. 11 сарын 26-нд Энэтхэг улсын Засгийн газрын зүгээс нь шийдээд, бид нар чинь бол Засгийн газраас нь биш Эксим банкнаас авч байгаа. Эксим банкнаас зээлийн гэрээний төсөл сая 12 сарын 25-нд Гадаад яамаар дамжиж албан ёсоор ирсэн юм. Тэгэхээр энд ирүүлсэн зээлийн гэрээн дээрээ 2 талаасаа хэлэлцээр хийж суугаад, өнгөрсөн 7 хоногт дуусаад, ингээд 2,3 Байнгын хороогоор хэлэлцэхээр зөвшилцөхөөр 1 дэх өдөр Их Хурал руу хүргүүлсэн байгаа. Ингээд явж байгаа.

Тийм учраас соёрхон батлаад зээлийн хэлэлцээр бүр бүрэн Их Хурлаар ороод, гараад ингээд зээлийн ашиглалтад орох ийм боломж нь үүснэ гэсэн үг. Хэрвээ өнөөдөр бид энэ жилийнхээ зээлийн ашиглалтыг нэлээн том дүнтэй байж байгаад ажлыг нэлээн урагшлуулъя гэвэл одоо байгаа бид нар төсвийнхөө дүрмээрээ төсвийнхөө зардал талдаа заавал тусгахаас өөр арга байхгүй. Нэмж дүнгээ. Тийм учраас тодотгол хийх ийм нөхцөл үүснэ гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Би ер нь Ганбаатар гишүүнтэй санал нэгдэж байгаа. Тэгээд Туваан сайд хүндэтгэн үзэх шалтгаантай энэ хуралд оролцохгүй байгаа юм уу эсвэл шалтгаангүй байхгүй байгаад байгаа юм уу. Уул уухайн яамтай холбоотой л олон асуудлууд байна л даа. Энэ чинь төсөл хэрэгжүүлэгч нь. Сайд чинь байгаа юм уу. Одоо тэгэхээр чинь хэнээсээ асуух уу. Даргын зөвлөлийн хурал дээр ер нь энэ асуудлыг ярьсан. Зарим гишүүд бас мэдэхгүй байгаа байх. Хэд хэдэн нэн чухал асуудал дээр Туваан сайд худлаа мэдээлэл өгсөн. Бичээд аваарай, тэр сайддаа хэлээрэй. Тэр хий дамжуулах хоолойтой холбоотой, тэгээд бид нар чинь яах вэ, улс төрийн хүмүүс. Нөгөө техник, технологийн нарийн ширийн юмыг нь мэдэхгүй Туваан сайдыг мэднэ гэж бодож л итгэсэн. Дандаа худлаа ярьсан байна лээ. Бүгдийг нь нягталж үзсэн. Хэд хэдэн асуудал дээр. Угаасаа тэр аудио, видео бичлэгтэйгээ протоколтой байгаа. Чуулган дээр энийг ярина. Гүйцэтгэлийн аудит хийгдсэн гэсэн санхүүгийн. Тэгсэн сүүлдээ нөгөөдөх нь Италийн компани зураг төсөл дээр хөндлөнгийн хяналтын аудит хийгдсэн гээд. Тэгээд Ганбаатар гишүүн ээ, та бид 2 маш сайн ойлгож энийг бичиж тэмдэглэж авсан. Сангийн яам энэ гүйцэтгэлийн аудитыг бас шаардсан. Сангийн яам ч энэ мэдээлэл ердөөсөө ирээгүй байх. Тэгэхээр гүйцэтгэлийн аудит байхгүйгээр бид цаашаа харна гэдэг маш хүнд байгаад байгаа байхгүй юу. 268 сая долларын хөрөнгө оруулалт хийгдчихсэн. Бодитой ажлууд явагдаж байгаа. Тэр дээр аудит хийгдсэн зүйл юу ч байхгүй. Хийгдлээ гэхэд нийт энэ зээлийн багц чинь 1,7 тэрбум доллар. Магадгүй

хэмнэгдэх нөхцөл байдал үүсэхэд энэ гэрээний нөхцөлүүд маань яаж зохицуулагдах вэ 1-д.

2-т гэхээр ер нь том зургаараа нийтдээ 2,2 тэрбум долларын хөрөнгө оруулалттай энэ төсөл маань төсвөөс 1 ч төгрөг гаргахгүйгээр өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтыг нөхөж чадах уу.

3-д нь юу вэ гэхээр явж, явж түүхий эдийн л хангамжийн асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд Уул уурхайн яамны төлөөлөл энэ залуу түрүүн бас хэлээд байна. Яг одоо ашиглалтын нөөц нь үндсэндээ 31 сая тонн гэж байна. Гэтэл нөгөө Петро Чайнагийн олборлож байгаа нь жилдээ 500 мянга орчим тонн юм шиг байгаа юм. Тэгээд энийг нэмэгдүүлнэ, нэмэгдүүлэх. Тэгээд Петро Чайнатай бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ дагуу ямар үнэ ханшаар авах вэ. Ингээд бүх юм ойлгомжгүй байгаад байна л даа. Тодорхойгүй. Тэгээд зүгээр дандаа амаар хэлцэл хийчихсэнийгээ л яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр ямар ч байсан Сангийн яам байгаа дээр энэ өөрөө өртгөө 100 хувь нөхөөд төсөвт дарамт .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Туваан сайдтай л яримаар байна л даа энийг. Тэгээд өөрөө байхгүй байгаад байх юм. Тэгэхээр нөгөө 2,2 тэрбум доллароо энэ төсөл маань үйлдвэр болоод өөрөө нөхөх юм байгаа биз дээ. Төсөвт дарамт учрахгүй юм байгаа биз дээ. Дээрээс нь хөндлөнгийн гүйцэтгэлийн аудитууд хийгдээд, тоо буурвал яах вэ. Тэгвэл нөгөө хэлэлцээрийнх нь дагуу бид энэ дээрээ тодотгол хийх боломжууд нь бас байгаа юу. Тэгээд Петро Чайнатай холбоотой. Ер нь энэ Туваан сайдаас асуух 20-иод асуулт байгаа. Тэгээд энэ нөхдүүдээс асуугаад одоо юу ч асуух вэ дээ. Ер нь маш их худлаа ярьсан шүү. Тэр Алтанцэцэг дарга та өөрөө сууж байсан. Туваан сайд нь өөрөө ч асуудлаа мэддэггүй юм байна лээ. Тэгээд араас нь шипи өгөх юм. Даргын зөвлөлийн хурал дээр ер нь бас их дэмжихээр юм байна гэдэг ойлголт авчихсан. Тэгээд яг шалгаад үзэнгүүт бүгд худлаа байсан шүү.

Г.Тэмүүлэн: Санал гэж ойлголоо. Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Энэ төсөлтэй холбоотой хэрхэн яагаад удааширсан, юуны улмаас удааширсан

Г.Тэмүүлэн: Уучлаарай. Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Гараа өргөөрэй. 4 номер. Уул уурхайн яам Хишигдалай.

Ч.Хишигдалай: 2023 оны 9 сард уг үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн. Энэ дээр санхүүгийн шинжээчид бас ажилласан. Үйлдвэрийн эргэн төлөх хугацаа гэрээ тус бүрийн хувьд зээл олгож эхэлсэн өдрөөс хойш 7 жил байхаар шийдвэрлэснээр И Пи Си 2, И Пи Си 3 багц ажлыг санхүүжүүлэх зээлийн эргэн төлөлт 2030 оноос эхлэхээр авч үзсэн байна. 1 дүгээр хувилбараар зөвхөн газрын тос боловсруулах үйлдвэрийн зээлийн эргэн төлөлтийг тооцож, хөрөнгө оруулалтын зардлыг 1 тэрбум 698,2 сая ам.доллараар хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн түвшнийг 14,9, өнөөгийн цэвэр үнэ 606,2 сая ам.доллар. Хөрөнгө оруулалт, эргэн төлөгдөх хугацаа 6 жил гэж тооцоолсон байна.

2 дугаар хувилбар газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолойн зээлийн эргэн төлөлтийг тооцож, хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн түвшнийг 12 хувиар, өнөөгийн цэвэр үнэ 292,5 сая ам.доллар. Хөрөнгө оруулалт эргэн төлөгдөх хугацааг 7 жил гэж тооцоолсон байна.

3 дахь хувилбар нь газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, Хөгжлийн банкны зээл бүгдийг нь нэмээд, хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн түвшнийг 11,4 хувиар өнөөгийн цэвэр үнэ цэн 215 сая ам.доллар. Хөрөнгө оруулалт, эргэн төлөгдөх хугацааг 8 жил гэж тооцоолсон байна гээд санхүүгийн тооцооллын шинжээч бол ийм дүгнэлт гаргасан.

Г.Тэмүүлэн: Номтойбаяр гишүүн нэмж тодруулъя.

Н.Номтойбаяр: Наадах чинь хаанахын санхүүгийн шинжээч гэнэ ээ. Үгүй ээ, наадах чинь ингээд Энэтхэгүүд нь өөрсдөө ТЭЗҮ-ээ хийгээд, Энэтхэгүүд нь өөрсдөө барьж гүйцэтгэх, Энэтхэгүүд нь өөрсдөө прожект менежментээ ажлаа хийгээд, Мэдэхгүй. Энэ ямар сонин тогтоцтой бизнесийн загвар яваад байгааг ёстой Хойд Солонгос, манай 2-т л байдаг байх. Ийм дампуу, тэнэг бизнесийн тогтолцоо хаанаас та хэд сурсан юм бэ. Тэгээд И пи си 1-хээ хүрээнд прожект менежментийн 73,9 сая доллар байгаа биз дээ. Анхнаасаа И Пи Си эм байгуулчихгүй яасан юм ер нь. Тэгээд эцсийн дүндээ би нэг л юм асуугаад байгаа шүү дээ. Төсөвт санхүүгийн дарамт учруулахгүйгээр энэ төсөл чинь хэрэгжээд өөрөө өөрийнхөө хөрөнгө оруулалтыг нөхөж чадах юм уу л гээд байна шүү дээ. Тэр санхүүгийн шинжээчийн дүгнэлт гээд байгаа тэр материалууд чинь хаана байгаад байгаа юм бэ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Хэн хариулах вэ. 5 номер. Алтанцэцэг захирал.

Д.Алтанцэцэг: Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд юу гэж тусгасан байгаа вэ гэхээр бүх ерөнхий гүйцэтгэгчид, зөвлөх компаниуд Бүгд Найрамдах Энэтхэг Улсынх байна гээд заачихсан байгаа. Тийм учраас бид нар ерөнхий гүйцэтгэгчдийг, төслийн менежментийн зөвлөхийг Энэтхэгээс сонгох ийм үүрэгтэй байгаа юм. Энэ бол бид нарын ажилтай бол шууд холбоогүй. Өмнө нь байгуулчихсан. 2016 онд байгуулсан гэрээнд бол тэгж тусгасан байна.

И Пи Си гэрээ бол түлхүүр гардуулах нөхцөлтэй бүх л үнийн дүнтэй гэрээ. Тэгэхээр одоо энэ үнэ бол ТЭЗҮ-ээр гарсан дүн бол 1 тэрбум 236. Ингээд 34 хувиар бол өссөн. 2 шалтгаанаар бол өссөн байгаа.

Нэг нь, техникийн шалтгаантай. Тэр нь юу вэ гэхээр ТЭЗҮ-ийн дараа үйлдвэрийн инженерчлэл, оновчлол хийхэд нэлээд олон төрлийн өөрчлөлтийг дандаа үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, түвэгшлийг .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд хариулъя 5 номер.

Д.Алтанцэцэг: Тоног төхөөрөмжийн эдэлгээг уртасгах, өөрийн орны бусад стандартын шаардлага, тээвэр логистик энэ тэрд тохируулах ийм өөрчлөлтүүд гарсан. Дээрээс нь зарим бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэхээр тэр гидро

цэвэрлэгээ, гидро крейкинг энэ тэрийн хүчин чадал бол ТЭЗҮ-д төлөвлөгдсөнөөс бол өссөн байгаа.

2 дахь шалтгаан нь болохоор энэ дэлхий дахинд үүссэн цар тахалтай холбоотойгоор үүсээд, тэгээд буцаж дорвитой буураагүй ийм үнийн өсөлтүүд байж байгаа. Тоног төхөөрөмж нийлүүлэгчид бол тендерт орж байгаа компаниудад үнээ өгөхдөө бол харьцангуй нэлээн өндөр өсгөсөн үнийн дүнгүүд ирж байгаа юм. Дээрээс нь тээвэр логистикийн зардал гээд бас гадаадын далайн тээвэр үнэтэй болсон гээд ийм шалтгаанууд бол бас төслийн тодотголд бол яригдсан байгаа. Үйлдвэр бол 1,7 тэрбум төгрөгийн долларын хөрөнгө оруулалт хийгээд, бүх зээлээ эргэн төлөхөд нэмэх ашигтай гарна. 25 хувийн ААНОАТ төлөөд .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Монголчууд бид бүгдээрээ л газрын тос боловсруулах үйлдвэртэй болохыг хүссэн. Тэгээд анх 2017, 2018 онд зарлагдсан энэ төсөл өнөөг хүртэл ийм удаашралттай явааг бол бүгдээрээ мэдэж байна. Тэгэхээр энэ төслийн гүйцэтгэлтэй холбоотой, түүхий эдтэй холбоотой, гарах бүтээгдэхүүнтэй холбоотой, ТЭЗҮ-тэй холбоотой маш олон асуудал байгаа боловч нэгэнт Улсын Их Хуралд энэ зээлийн хэлэлцээр орж ирж байгаа учраас яг энэ зээлийн хэлэлцээртэй холбоотой зүйлүүдийг өнөөдрийн тухайд тодруулж асууя.

1 дүгээрт энэ ТЭЗҮ өсөж батлагдсан өдөр нь бол 2023 оны 9 дүгээр сарын 27 юм байна шүү дээ. Тэгэхээр тэр цагаас хойш өөрөөр хэлбэл өмнөх Засгийн газрын үед энэ ТЭЗҮ-ийн тодотгол хийгдээд явсан гэж ойлголоо. Тэгэхээр тэр цагаас хойш ингээд бүтэн жил Энэтхэгийн талтай хэлэлцээр хийж байж Эксим банк нэмэлт 400 сая долларыг санхүүжүүлэх шийдвэр гаргасан гэж ойлголоо. Тэгэхээр энэ хугацаанд ер нь ажил хийгдсэн үү. Ямар нэгэн зарцуулалт, санхүүжилт хийгдээд бүтээн байгуулалт хийгдсэн үү гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаарт нь болохоор энэ зээлийн гэрээнд ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд тооцогдох жилийн шимтгэл гээд 0,5 хувийн хүүтэй байгаа юм байна. Тэгээд одоо энэ шимтгэл бодогдож байгаа юу. Ер нь 2018 онд анх энэ гэрээ байгуулагдсанаас хойш энэ шимтгэл бодогдож байгаа. Энэ дээр бид нар ямар нэгэн төлбөр хийсэн зүйл байгаа юу. Тэгээд бид үндсэн төлбөрөө 2023 оноос төлж эхлэх ёстой байсан гэлээ. 64 сая орчим доллар. Тэгэнгүүт тэрийг бол 13 сая болгоод бууруулчихсан гээд энэ танилцуулга дээр биччихсэн байна. Энэ 13,1 сая ам.долларыг манайх төлсөн юм уу. Тэгээд ер нь энэ зээл дээр ямар хүүгийн төлбөр бодогдож байгаа вэ. Одоогоор бид нар төлчихсөн зүйлүүд юу байгаа вэ гэдгийг бас тодруулъя. Тэгээд энэ зээлийн гэрээ дээр болохлоор үндсэн зээлийн эргэн төлөгдөх хуваарь хавсаргачихсан байгаа боловч хүүгийн тооцоолол огт хавсаргагдаагүй байгаад байна. Тэгээд энэ хүүгийн ер нь тооцоолол ямар байдалтай байх вэ. 36 сарын дотор гүйцэтгэлээ гэж үзэхэд.

Эцэст нь болохлоор бас дахиад нэг асуулт байгаа нь эхний ээлжид энэ асуултад хариу авчихъя.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Манай ажлын хэсгээс нэмж хариулаарай. Зарим тоонуудаа. Тийм ээ, 2023 оны 9 сарын 27-нд Эрдэс

баялгийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр сүүлийн байдлаар энэ ТЭЗҮ нь ингэж гарсан. Ингээд Энэтхэгийн талд хүсэлтээ тавиад ингэж бараг жил гаруй хугацаанд хэлэлцээр хийсэн юм байгаа юм. Энэ хооронд И Пи Си 1 нь дууссан 2, 3 нь бол тодорхой хэмжээнд явсан. Нийтдээ 268 сая долларын зарцуулалт гарсан гэсэн үг. Одоо энэ дүн бол энэ ихэнх нь И Пи Си 4 дээр орох юм байгаа юм буюу яг гол тэр нөгөө технологийн үйлдвэрийн нөгөө лиценз бүхий технологийн үйлдвэрийн хэсэг нь гэсэн үг. Коммитмент болон энэ зээлийн үндсэн нөхцөлүүд бол бүгд 2019 онд анх нөгөө гэрээ хийгдэхэд хийгдсэн тэр нөхцөлөөрөө үргэлжилж байгаа гэсэн үг. 1,75 жилийн хүү нь.

Коммитмент Пи 0,5. Энэ дээр төлбөр хийгдэлгүй яах вэ, хийгдээд явж байгаа. Тэгээд тэр 64 сая долларыг бид нар 13 болгож буулгасан юм. Тэр нь бүр тэр ковидын үед ажил нь зогсчихоод байхад, бид нар зээлээ ашиглаж чадаагүй байхад үндсэн энэ чинь 110-аад сая долларын зарцуулалт дөнгөж гарчихсан байхад бараг 64 сая доллар нь хэрэгжүүлэх төлөх ийм хугацаа болчихсон байсныг нь хойшлуулаад 2029 оноос үндсэн төлбөрүүд нь явахаар. Тэгээд мөн энэ чинь нөгөө нэг том дүнгээсээ үндсэн төлбөрүүд нь явах бас ийм хуучин гэрээтэй байсан юм. Тэрийг нь бид нар том дүнг нь И Пи Си 1, 2, 3, 4 гээд 4 хэсэг болгоод ашиглаагүй хэсэг дээрээ бол үндсэн төлбөр хүү байхгүй, зөвхөн яг ашигласан И Пи Си 2, 3 дээрээ үндсэн төлбөр хүү бодогдоод явахаар ингээд багасгаж чадчихсан юм.

13 н сая доллароор бид нар 2023, 2024 онд 2 жил таргалаад төлчхөөд байгаа. Тэр хүүгийн тооцоонуудыг хэлээдхээч манайхан.

Г.Тэмүүлэн: 7 номер нэмж хариулъя. Сангийн яамны өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох.

Л.Гантогтох: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Хүүгийн хувьд бол бид нар яг Энэтхэгийн зээл дээр одоогийн байдлаар нийт 7,9 сая ам.долларын хүү төлөөд байгаа. Жил болгон 1,75 хувиар гэрээнд тусгагдсаны дагуу төлөлтүүдийг хийнэ. Ашигласан зээлээсээ. Хүүгийн төлбөр бол яг бид нар ашигласан зээлээсээ яг 1,75 хувиар ингээд бодогдоод явдаг байгаа. Тэгээд одоо хүртэл төлөгдсөн төлбөр бол 7,9 сая ам.доллар.

0,5% бол гэрээ байгуулагдаад ашиглагдаагүй үнийн дүнгээс 0,5 хувиар бодогддог. Энэ бол ерөнхийдөө бусад гадаад зээлийн гэрээнүүд ч гэсэн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж буюу коммитент пи 0,5 хувь гэдэг ийм жишиг хүү байгаад байгаа. Энд одоо хүртэл төлсөн нийт төлбөрийн хэмжээ бол 10,1 сая ам.доллар байна.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүн нэмж тодруулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр хүүнүүд бол бодогдоод яваад байгаа юм байна. Өнгөрсөн хугацаанд бол ерөнхийдөө бол бараг 30 орчим сая доллар төлчихсөн байгаа гэж ойлгох уу. Саяын та хэдийн хэлсэн тоонуудыг нийлүүлээд үзэхлээр. Тэгэхээр нөгөө гүйцэтгэл удаашраад байх тусам энэ ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд тооцогдож жилийн шимтгэл энэ тэр тооцогдоод л явна гэсэн үг байна. Тэгээд энэ зээлийн хэлэлцээрт бас дефолт хүү гээд нэг хүү ороод ирчихсэн байгаа тээ. Хэрэв манайх төлбөрөө төлөхгүй нөхцөлд дефолт хүү гээд 2 хувийн хүү нэмж төлөгдөхөөр гэж ойлгож байна зөв үү. 1 дүгээр асуулт.

Тэгээд би Алтанцэцэг захирлаас нэг зүйл асуумаар байна. Та хэзээнээс эхэлж яг энэ төсөл дээр ажилласан бэ. Танай төслийн баг яг тэр компани хэдэн ажилтантай вэ. Таны өөрийн чинь цалин хэд вэ.

Г.Тэмүүлэн: Асуултуудад хариулъя. 5 номер.

Д.Алтанцэцэг: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Би “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” компанид 2017 оны 5 сараас орж ажилласан. Энэ компани 2017 оны 4 сарын 4-нд байгуулагдсан. 2018 оны 12 сарын 5-аас гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Өмнө нь Цэрэнноров гэж захирал байсан. ТЭЗҮ хийж байх үед.

Манай компани одоо 88 хүн ажилладаг. Бид бол уг нь 2000 оноос шат дараалаад инженер техникийн ажиллагсдаа бэлдээд, манай зураг төслөөс өгсүүлээд барилга угсралт дээр нь оролцоод, үйлдвэрийнхээ инженерүүдийг бэлтгэсэн боловч манайд үнэхээр инженерийн мэргэжилтэй, ажиллах сонирхолтой хүмүүс бас тэр болгон олдохгүй бид үргэлж зар тавиад энэ асуудал байгаа. Бид энэ жилийнхээ бүтцийг 128 хүний орон тоотойгоор батлуулах гээд өгсөн байгаа. Хөлсөөр ажилладаг 10 хэдэн хүн байдаг. Тэр бол орон нутагт үйлчилгээний ажил .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 7 номер нэмж хариулъя.

Л.Гантогтох: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Зээлийн гэрээ дээр бол ийм дефолт хүү буюу хэрвээ бид нар Монгол Улсын Засгийн газар гэрээнд заасан хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд тооцогдох алдангийн хувь гэсэн үг. Энэ хувь бол 2 хувь байгаа. Тэгэхдээ манай шинээр байгуулж байгаа энэ зээлийн гэрээ дээр бол Монгол Улсын Засгийн газар нэлээн том хариуцлага хүлээж байгаа. Хугацаандаа төлбөрөө байнга төлөх ёстой. Тэгэхээр хэрвээ хугацаа хэтрүүлсэн тохиолдолд тооцогдохгүй байгаа. Тэгэхээр хугацаандаа төлөөд явж байхад бол ямар нэгэн байдлаар энэ хүү бол бодогдохгүй.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу. Бадамсүрэн гишүүнээр тасалъя. Батбаатар гишүүн үг хэлнэ.

Б.Батбаатар: Сая уг нь нэг асуулт асуух гэж байгаад кноп ажиллаагүй юм. Яасан юм байгаа юм. Энэ зээлийн хэлэлцээр, газрын тос үйлдвэр, Монголын хэрэглээ, одоогийн геополитик нөхцөл байдал гээд олон юмыг холиод яриад эхлэхээр энэ төслийг гэдэг юм уу газрын тостой болох, үйлдвэртэй болох энэ төслийг нөгөө эсэргүүцэхэд их хүнд болчхож байгаа юм. Эсэргүүцэх биш харин дэмжих ёстой болчхож байгаа юм. Тэгээд дэмжих ёстой зүйлийг, улс оронд хэрэгтэй зүйлийг дагаж явж байгаа процесс нь тэр үйлдвэрийг байгуулах гэж байгаа гэрээ, хэлэлцээр, ТЭЗҮ, байгаль орчны нөлөөлөл, дээрээс нь хэрэгжүүлж байгаа хүмүүсийн зөрүүтэй болон тодорхой бус мэдээллүүдээс болоод ирэхээр эргэлзээд эхэлж байгаа. Бид бол Засгийн газар бүрдсэнээс хойших 6 сарын хугацаанд болж өгвөл Монгол Улсад хэрэгтэй МАН, АН, ХҮН намын нийлсэн 118 их хурлын гишүүнтэй, 118 хулгайч биш л байлгүй. Нийлээд энэ улс оронд хэрэгтэй зүйлийг хийх гэж байна гэж бодож, тэрэнд нь чөдөр тушаа болохгүй байхыг хичээгээд байдаг. Тэгэхээр Засгийн газар талаасаа тэр түрүүн гишүүдийн асуугаад байгаа ТЭЗҮ болон бусад мэдээллүүдийг урьдчилаад Их Хурлын гишүүдийг

мэдээллээр гүйцэт хангаагүй тохиолдолд гаргах шийдвэрээ бас мэдэхээ больчлоод байдаг.

Тийм болохоор энэ төслийг нэг бол дахиж хойшлуулна гэхээр энэ чинь яадаг билээ дээ. Уначихаараа тэр чигээрээ яваад өгнө шүү дээ. Дахиад хэдэн сар болж ирэх ч билүү, үгүй ч билүү. Тийм хэмжээнд Засгийн газар мэдээлэл өгч байна. Хараад үзье гэхээр үзэх юм маш дутуу байна. Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр яриад байсан зүйлүүд, энд ирээд яригдаж байгаа зүйлүүд бусад талаас ингээд сонсогдож байгаа зүйлүүдийг нь харахаар ирээдүйд энэ төслийг хэрэгжүүлж байгаа Монголд бол их мөнгө. Тэрийг төлөх ганцхан төлбөр төлөгч нь 3,5 сая магадгүй 4 саяулаа болсон ч 4 саяулаа төлнө. Харин дундаас нь гадаад, дотоодын дарга нар ямар нэг байдлаар хулгай хийчихсэн бол тэд нар төлөхгүй шүү дээ.

Тэгэхээр ийм эргэлзээтэй нөхцөл байдлыг яаж санал өгөх вэ гэж бодох ёстой болчлоод байдаг. Засгийн газар битгий гаргаад байгаач ээ. Засгийн газрын харьяа агентлагууд, сайд, дарга нар. Тэгээд энэ асуудал хэлэлцэж байхад салбарынх нь сайдууд орж ирдэггүй. Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо дээр асуулт асуух гэж байхад сайд нь гараад явчихсан. Уржигдар. Асуултаа больсон шүү дээ. Сайд нь байхгүй юугаа асуух юм. Одоо өнөөдөр чуулган завсарлах гэж байна гэж байдаг. Хаврын чуулган эхлэхэд бол шал өөр хандлагаар, өөр байдлаар ажиллахгүй бол манай энэ засаг болохгүй зүг рүүгээ явж эхэлж байна.

Ардын нам, АН, ХҮН нам гэдэг 118 гишүүнтэйгийнхээ тэр бяраар арай л хэтрээд байх шиг байх юм. Нэг бол энэ ажиллаж байгаа хүмүүстээ жоохон анхаарал, зүй ёсны, анхаарал тавиач ээ л гэж хүсмээр байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ганбаатар гишүүн үг хэлье.

С.Ганбаатар: Нефтийн үйлдвэртэй болно гэдэг бол манай тусгаар тогтнолын асуудал. Үнэхээр бид бүгд дэмжиж байгаа. Би 2020-2024 онд гишүүн байхад 2 удаа энэ нефтийн үйлдвэр дээр очиж, дэмжиж байна. Ямар бололцоогоор дэмжих вэ, юу саад болж байна гэж асууж байсан. Тэгэхдээ ТЭЗҮ, тооцоо судалгаа байхгүйгээр бид харанхуй зүгээр мөрөөдөлдөө итгэнэ гэж байхгүй. Зах дээр нэг талх эсвэл боорцог, эсвэл цагаан сарынхаа гурилыг худалдаж авах гэж байгаа юм шиг ам наймаа хийдгээ зогсооё. Үгүй ээ, энэ чинь цэцэрлэгийн өргөтгөл барих гээд л тойрог дээрээ бид чинь тэгээд л нэг ТЭЗҮ, зураг төсөв гээд л ерөөсөө маш их зүдэрдэг шүү дээ. Тэгэхэд чинь энэ олон 100 сая доллар ийм ам наймаагаар явж болохгүй ээ. Надад 27 асуулт байна. Энэ төсөл явахын тулд түүхий нефтийн нөөц байна уу, юу ч байхгүй, юу ч байхгүй. Өмнөх даргын зөвлөлийн хурал дээр бол Энэтхэгүүд тэр талбай дээр одоо хайгуул хийж эхэлж байгаа л гэж ярьж байсан.

2-т нь байгаль орчинд нарийвчилсан нөлөөллийн үнэлгээ байна уу. Байхгүй. Усны асуудал. Энэ нефтийн үйлдвэр дээр бол ус бол ерөөсөө хамгийн чухал.

3 дугаарт нь. Та нар газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдээр тосоор хангах асуудлыг хамгийн зохистой байх ёстой. Хятадуудтай ярьчихсан л гээд л ам яриад байна. Протоколд байгаа л гэж ярьж байна. 3 удаа Хятадууд нийлүүлж чадахгүй шүү. Бид өөрсдийнхөө эрх хэмжээг өөрийнхөө зүйлийг нийлүүлнэ, өөрийнхөө үйлдвэрийг нийлүүлнэ гэж ярьсан. Хэнд нь итгэх юм бэ. Зүгээр цаасаа үзүүл л дээ. ТЭЗҮ-ээ өнөөдөр бид гишүүдэд авчирч өгөхгүйгээр

харанхуй зүгээр кнопоо даруулна гэж байгаа бол энэ гэмт хэрэг болно шүү. Энэ олон 100 сая долларын асуудал ярьж байгаа шүү.

Хамгийн аюултай ноцтой юм нь Энэтхэгийн Эксим банктай байгуулсан гэрээний дагуу Энэтхэгийн тал төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагаа, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, үнэ өртөг, цаг хугацааны талаар ямарваа нэгэн мэдээллийг өгөх үүрэг захиалагчийн өмнө хүлээгээгүй. Тэд ямар ч харанхуй мэдээлэлгүй байгаа шүү дээ. Өнөөдөр төсөл хэрэгжүүлэгч ерөнхий төсөл хэрэгжүүлэгч нь тодорхой байна уу. Байхгүй. Тодорхойгүй. Энэ үйлдвэрийг барьж байгуулахад амин чухал асуудал болох технологийн лицензийн гэрээ байгаа юу. Байхгүй. Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажлын график, төлөвлөгөө гээд И Пи си гээд л яриад байгаа. И Пи Си хуваарийг бүр бүрэн үзмээр байна шүү дээ. Амаар яриад л байдаг. Би болж өгвөл хүний нэр хүндэд халдахгүй, ярихгүй гэж хичээгээд байгаа шүү дээ. Хичээж байгаа, зүтгэж байгаа, чармайж байгаа. Тэгэхдээ дээрэлхэхийг, гишүүдийг доромжлохыг бол хүлээн зөвшөөрөхгүй шүү. Ямар гоё гоё англи үг хэлж, толгой эргүүлэх луйварчин биш дээ ямар.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн судалгаагаар эдийн засгийн хувьд үр ашигтай байхын тулд Дэлхийн банкны баталсан даган мөрдөх журмын дагуу ТЭЗҮ, судалгаа физибилити стадийг хийсэн байх ёстой шүү. ТЭЗҮ-ээ харж байж энэ миний яриад байгаа энэ усны болон нөөцийн болон энэ бүх асуудлуудыг цаасыг нь үзэж байж энэ олон 100 сая долларынхоо шийдвэрийг гишүүд минь гаргаарай. Гаргахгүй бол та нар Оюутолгойн хэдэн нөхдүүд маань яаж шонд өлгөгдөж, яаж зовж зүдэрч байгаа билээ. Та нарыгаа аврах гэж өнөөдөр ярьж байна шүү. Монголын ард түмнийгээ аврах гэж ярьж байна шүү. Газрын тосны нефттэй, нефтийн үйлдвэртэй болох гэж би энийг ярьж байна шүү. Хэзээ ч босохооргүйгээр унахгүйн тулд би энийг ярьж байна шүү. Би үгээ хэлж дууслаа. Чуулган дээр үг хэлнэ.

Г.Тэмүүлэн: Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Үндэсний газрын тос боловсруулах үйлдвэртэй болохыг дэмжиж байгаа. Эдийн засгийн байнгын хороо дээр энэ талаар тодорхой саналуудаа хэлсэн. Энийгээ бас дахиад яг үндсэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр хэлэх нь зүйтэй гэж бодож, ер нь их сэтгэл зовниод би бас энэ Байнгын хорооны хуралдаан дээр орж ирж хэлж байна.

1 дүгээрт бол Улсын Их Хурлаас гаргах зөвшилцөх энэ шийдвэр дээр тодорхой саналуудыг тусгуулъя гэсэн ийм хүсэлтэй байна. Байнгын хорооны даргад хандаж. 1 дүгээрт бол дахиад 1 ч төгрөгийн төсөв энэ дээр нэмэхгүй байх ёстой. Улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс.

2-т нь 1 ч төгрөгийн зээл нэмж авахгүй байх ёстой.

3 дугаарт нь энэ төслийг яг заасан тэр 36 сарын хугацаанд нь зайлшгүй ашиглалтад оруулах ёстой. Үүнээс цааш газар үгүй гэдэг шиг үүнээс хойш 1 ч хоног байх ёсгүй.

4 дүгээрт нь жил болгоны эцэст улсын төсөв хэлэлцэх үеэр үүний явцыг дүгнэдэг байх ёстой. Дүгнээд хэрвээ хангалтгүй хэрэгжсэн бол холбогдох албан тушаалтанд заавал хариуцлага тооцож, ард түмэнд мэдээлж, зарлах ёстой.

Тэгэхийн тулд улирлаар нь энэ график, гүйцэтгэлийн төлөвлөгөөг нь гаргуулж энийг эрх бүхий албан тушаалтан, байгууллага баталж, энэ дээр нь ард түмний өмнөөс хяналт тавих ёстой.

Би бол Аж үйлдвэрийн бодлогын байнгын хорооны гишүүний хувьд бол энэ дээр хяналт тавих ажилд Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль дээр заасан эрх, үүргийнхээ хүрээнд энд бол заавал оролцоно гэдгээ бас энд зориуд хэлье.

Дараагийнх нь бол энэ бүх зарлагдаж байгаа бараа ажил үйлчилгээг нээлттэй ил тод зарлах ёстой. Энэ дээр төр, Засгийн газар хяналт тавих ёстой. Тэгэхгүй бол энэ нь бол ард түмний дунд маш их ийм хардлага байгаа. 7 их наяд гаруй төгрөг болж байгаа. 7 их наяд гаруй шүү. Энэ бол Дорнодын ДЦС 50мвт-ын станцыг 20-ийг барих хэмжээний мөнгө. Тэгэхээр энэ дээр бол ийм зүйл.

2 дахь гол зүйл нь түүхий эдийн нөөц. Түүхий эдийн нөөц бүрдүүлэх ажлыг энэ үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилтай параллелийн давхар явуулахгүй бол үйлдвэр нь ажилд ордог. Түүхий эд байхгүй бол энэ ажиллахгүй. Энэ үйлдвэр 1 сая 500-г биш 1 сая юм уу, 500 мянгыг боловсруулах юм бол маш их хэмжээний алдагдалд орно. Тийм учраас энэ зүйл дээр онцгой анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл хонх нь дуугарахаар дамар нь таг, хоёулаа дуугарахаар лам нь таг гэдэг шиг үйлдвэр нь ашиглалтад ордог түүхий эдийн нөөцгүй бол яах вэ.

Тийм учраас энэ түүхий эд олборлох асуудлаа гаднын компанид даалгачаад тэд нартай яриа хэлцэл хийсэн гээд сууж байж болохгүй. Энэ газрын тосны үйлдвэрийг чинь дэмжих тухай Улсын Их Хурлын бие даасан хууль хүртэл гарсан. Энэ Үндэсний баялгийн санд байгаа хөрөнгөөсөө бусад эх үүсвэрээсээ энэ хуримтлалын санд, хөгжлийн санд байгаа энэ эх үүсвэрүүдээс хууль журмын дагуу үндэсний олборлолтын компани байгуулах энэ ажлыг заавал хийх ёстой. Энэ үйлдвэр нэг гэрийн нэг багана бол нөгөө багана нь түүхий эдийн бид нар нөөцийг илрүүлж олборлох энэ асуудал байгаа. Өнөөдөр 30 сая тонны нөөц үлдчихсэн байгаа. 10 саяыг нь экспортолчихсон байгаа гээд ярьж байгаа. Гэхдээ яг энэ 30 сая чинь байгаа юу. Өөрөөр хэлбэл бид нар экспортолно гэхээс илүүтэй одоо байгаа жоохон хөрсөн доор байгаа газрын тосоо энэ үйлдвэртээ ямар хугацаанд ашиглах вэ гэдэг зүйлээ л бодох ёстой. Тийм учраас энэ зүйл бол их томоохон асуудал шүү. Өнөөдөр яах вэ, нэг зээлийг нэмж авах хэлэлцээрийн асуудлыг ярьж байна. Тэгээд Их Хурал хэрвээ дэмжвэл саяын энд дурдсан асуудлуудыг заавал хэрэгжүүлээрэй гэдгийг би бас мэргэжлийн хүнийхээ хувьд, энэ газрын тос олборлож байгаа бүс нутагт ажиллаж, амьдарч байсан хүнийхээ хувьд энийг бол заавал хэлье гэж энийг онцгойлон бас .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Бадамсүрэн гишүүнд баярлалаа. Цогтбаатар гишүүн үг хэлнэ.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төслийг би цэвэр улс орны хөгжилд хэрэг болох уу, үгүй юу гэдэг талаас нь бид нар дүгнэж үзэж, ярьж байх ёстой болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхгүй бол сүүлийн үед ярихаараа л төсөл болгоныг ярихаараа л Монгол Улсын тусгаар тогтнол гээд яриад байх юм. Монгол Улсын тусгаар тогтнол гэдэг чинь нэг нефтийн үйлдвэртэй харьцуулшгүй том юм шүү дээ. Нефтийн үйлдвэрээс тусгаар тогтнол хамаарна гэсэн юм яриад байвал бид нар чинь 100 жил нефтийн үйлдвэргүй гэхдээ тусгаар тогтносон улс байгаад тэр НҮБ-д чинь элсчихсэн явж байгаа шүү дээ.

Тэгэхээр Монгол Улсын тусгаар тогтнолыг ийм жижиг түвшинд аваачиж яриад байж болохгүй. Харин энд хариуцлагатай хандах ёстой бол энэ бол өөр асуудал. Би энэ төслийг юу гэж харж байгаа вэ гэхээр энд үйлдвэрлэгдсэн түлш импортын түлшнээс хямд байгаад, Монголын үйлдвэрлэгчдэд импортын түлшнээс нь хямд түлш нийлүүлээд, Монголын хөгжилд хувь нэмэр оруулаад, ажлын байрыг бий болгоод, Монголын бизнесүүдийн хөгжилд тус нэмэр болох ийм хэмжээний л төсөл гэж харж байгаа. Түүнээс тусгаар тогтнолтой уях юм энд юу ч байхгүй. Энэ байхгүй болчихвол Монгол Улс байхгүй болчих гээд байгаа юм шиг. Энэ төсөлтэй, төсөлгүй Монгол Улс чинь оршин тогтноод явна. Тэгэхээр хэмжээ дамжаандаа юмнуудаа зүйрлэж ярьцгааж байх хэрэгтэй.

Харин гишүүдийн яриад байгаа санаа зовж байгаа асуудлуудад бол хараад байхад хариулт хангалтгүй байна шүү. Хариулт байх ёстой. Түүнээс энд асуух хэрэгтэй хүмүүс нь зарим нь ойлгохгүй ч асууж байж болно. Бид ойлгохгүй байх эрхтэй. Та нар ойлготол нь тайлбар, баримттай, тоотойгоор өгөх үүрэгтэй. Тэрийгээ харин биелүүлэх ёстой.

Тэгээд энэ дээр би нэг зүйл хэлмээр байгаа юм. Одоо хамгийн гол хэлэх гэж байгаа зүйл. Энэ үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн нь импортын түлшнээс хямдхан байх ёстой шүү. Тэгэхгүй бол дараа нь үйлдвэр барьчхаад өө одоо үндэсний үйлдвэр учраас үүнээс үнэтэй байх ёстой гээд илүү үнэтэйгээр Монголын хэрэглэгчдэд түлш нийлүүлээд, тэгээд ийм үнээр л бид нар эргүүлээд энэ зээлийг төлөх боломжтой юм гэдэг ийм асуудал харин ярихгүй шүү. Би энэ төслийг анх яригдаж байхад нь л энэ төслийн чинь үр дүнд гарах түлш чинь импортын түлшнээс хямд байна биз гээд асууж байсан. Алтаа захирал хямд байна гэж хэлж байсан. Би энийг зөвхөн яг энэ хүрээнд нь л авч үзнэ. Тэгээд тэр хямдаараа төсвөөс дэмжлэг авахгүйгээр, энэ өр зээлээ төлөөд дуусах боломжтой байгаа төслийг л сая арилжааны амьдрах чадвартай төсөл гэж үзнэ. Тэгээд иймээрээ байгаа гэж би ойлгож байгаа. Энэ өөрчлөгдөөгүй байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд ийм тохиолдолд бол энэ төсөл цаашаа урагшлаад явах ёстой. Түүнээс бол өөр төслийнх нь өөрийнх нь хэмжээнээс хэтийдсэн тийм зүйрлэл эд нараар зүрхээ дэлдээд л, цээжээ дэлдээд яриад байх хэрэггүй. Зүгээр маш эрүүл, бизнес утгаар нь л энийг харах ёстой л гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулахаар байгаа. Гишүүдийг Байнгын хорооны танхимд дуудаарай. Санал хураалтыг явуулж эхэлнэ. Тэгээд Сангийн яам, Уул уурхайн яамныхан бас саяын гишүүдийн хэлсэн саналууд дээр анхаарч ажиллаарай.

Сая бол Бадамсүрэн гишүүн бүр яг тов тодорхой саналыг хэллээ шүү. Энэ асуудал дээр бол нэг талдаа энэ төсөлтэй холбогдуулж цаашид бид нар энэ зээлийн төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс бол ямар нэг байдлаар зээл нэхэхгүй гэдэг асуудлыг тавьж гарч ирж байна. Дээрээс нь өөрөө энэ төсөв дээр бол нэмэлт зардал үүсгэхгүйгээр, дэмжлэг авахгүйгээр энэ төсөл бол цаашид өөрөө амьдрах чадвартай байх ёстой гэдэг асуудлыг ярьж байна.

Ингээд 36 сарынхаа хугацаанд буюу үлдэж байгаа энэ 3 жилийнхээ хугацаандаа бол заавал ч үгүй багтааж, хугацаандаа тусах ёстой гэдэг асуудлыг бол тавьж байна. Тэгээд 1 талдаа бол яах вэ, том зургаар бол ярьж байгаа зүйл бол өнгөрсөн энэ хугацаанд Ковидын нөлөөлөл мэдээж яах вэ байсан байх. Гэхдээ энэ төслийн бүтээн байгуулалттай холбоотойгоор, цаг хугацаатай холбоотойгоор,

хариуцлагатай холбоотойгоор асуудлыг бол гишүүд онцгойлон ярьж байна. Тэгэхээр Сангийн яам бол ер нь сая 2025 оны төсвийг бид нар батлах үед бүх ер нь зөвхөн газрын тос гэлтгүй, бусад бүх зээл тусламжийн асуудлуудтай холбоотойгоор зээлийн ашиглалтуудыг дүгнэж оруулж ир, эрэмбэлж оруулж ир. Цаашид юу гэдэг юм бид нар энэ асуудлууд дээр хэрхэх шаардлагагүй зээлүүдийг бол бараг болиулах гэдэг юм уу, энэ асуудлуудыг бол хянаж явж ярьж байгаа.

Тэгэхээр зээлийн ашиглалттай холбоотой, үр өгөөжтэй холбоотой энэ асуудлууд дээр бас хариуцлагатай хандана шүү. Хяналт хариуцлагаа сайжруулах зайлшгүй шаардлага байна гэдэг асуудлыг бол тавьж байгаа юм.

Ингээд санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Гишүүдээ санал хураалт.

Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэдгээр санал хураалт явна. Дэмжье гэдгээр. Техникийн саатал гарлаа. Би дахиад танилцуулах уу. Эрдэнэболд гишүүн ирцдээ орох уу.

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Гишүүд ирц болж байна уу.

Ингээд зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. 8 гишүүн дэмжлээ. Санал хураалтад 14 гишүүн оролцсон байна. Ингээд 57,1 хувиар дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулах байгаа. Илтгэгч гишүүнээр Энхтүвшин гишүүн танилцуулах уу та. Жангабыл гишүүн байгаа тийм ээ. Миний бие танилцуулъя.

Протоколд тэмдэглүүлэх нь “Хууль хүчингүй болсонд тооцох тухай” гэсэн хуулийн төслийг оруулж ирсэн. Энэ бол нэг талдаа тусдаа бие даасан хуулийн асуудлууд. Энийг бол хаврын чуулганаар тусдаа хэлэлцээд явна гэдэг зүйлийг бас протоколд тусгах байна.

Ингээд зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууссаныг мэдэгдье.

17.27 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ